

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.09.10-09.14

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Тээвэр, ложистикийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байв. Газрын тосны үнэ ихээр хэлбэлзсэн ч өсөлттэй хаагдлаа.

Энэ долоо хоногийн эхээр АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар БНХАУ-ын 200 тэрбум ам.доллартай тэнцэх импортын бараа бүтээгдэхүүнд 25%-ийн гаалийн татвар ногдуулна хэмээн мэдээлж, зах зээлийн индексүүд унаж эхэлсэн. Лхагва гарагт тус улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн зөвлөх Ларри Кадлоу худалдааны дайнаас сэргийлж, БНХАУ-тай худалдааны яриа хэлэлцээ дахин эхлүүлэх хүсэлт тавьсан хэмээн мэдэгдсэнээр зах зээлийн ханш өссөн байна.

Лхагва гарагт "Apple" компани эрүүл мэндийн тусгай функц агуулсан шинэ iPhone гар утас болон бугуйн цагийг олон нийтэд таницуулснаар тус компанийн хувьцааны ханш өсчээ.

8-р сард АНУ-ын хэрэглээний үнийн индексийн өсөлт саарч, өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад 2.7%-аар өсчээ. АНУ-ын Холбооны нөөцийн банкны эрх бүхий албан тушаалтнууд бодлогын хүүг өсгөх явцыг хойшлуулж магадгүй талаар мэдээлэв. Тус байгууллагын Мөнгөний бодлогын зөвлөлийн уулзалт 9-р сарын 25-26-ны өдрүүдэд болох юм.

**Европ:** АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал намжиж, Европын индексүүд өсөлттэй хаагдлаа. Авто машин үйлдвэрлэгч болон уул уурхайн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байв.

Английн болон Европын төв банкууд богино хугацааны бодлогын хүүндээ өөрчлөлт оруулалгүй хэвээр нь үлдээхээр шийдвэрлэлээ. Европын төв банк дунд хугацааны инфляцийн түвшинг 2 орчим хувьд хүргэх зорилготой байгаа юм. Түүнчлэн, тус байгууллага энэ оны 10-р сараас эхлэн бондын худалдан авалтаа 30 тэрбум еврогоос 15 тэрбум евро хүртэл багасгана хэмээн мэдээлсэн.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг суларч, 112 нэгж болов. Иенийн ханш суларснаар экспортын хэмжээ нэмэгдэж, хувьцаат компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны 2-р улиралд Япон улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 3.0% хүрсэн нь таамаглаж байснаас өндөр түвшинд байлаа. 6-р сард тус улсын бизнесийн болон хувийн хэрэглээний түвшин нэмэгдэж, ДНБ 0.7%-аар өсчээ.

**БНХАУ:** БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байна. Тус улсын эрх баригчдын мэдээлснээр 8-р сарын макро эдийн засгийн үзүүлэлтэд худалдааны маргааны асуудал төдийлөн нөлөө үзүүлээгүй аж.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,041.17	0.63% ▲
Dow Jones	АНУ	26,154.67	0.92% ▲
S&P 500	АНУ	2,904.98	1.16% ▲
Nasdaq	АНУ	8,010.04	1.36% ▲
S&P/TSX	Канад	16,013.49	-0.48% ▼
FTSE 100	Их Британи	7,304.04	0.36% ▲
S&P/ASX 200	Австрали	6,185.90	0.69% ▲
Nikkei 225	Япон	23,094.67	3.53% ▲
Hang Seng	Хонг Конг	27,286.41	1.16% ▲

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	108.31
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	95.85
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	95.31
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.59
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.33
TDBM' 2020	USD	9.3%	105.53

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.165	0.03 ▲
Libor 3M	2.337	0.01 ▲
Libor 6M	2.569	0.03 ▲
Libor 1YR	2.880	0.03 ▲
US 6M Bond	2.328	0.03 ▲
US 2YR Bond	2.778	0.08 ▲
US 3YR Bond	2.854	0.09 ▲
US 5YR Bond	2.903	0.09 ▲
US 10YR Bond	2.996	0.06 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.09.14	Өөрчлөлт
USD	2,497.65	0.73% ▲
CNY	364.73	0.58% ▲
EUR	2,927.12	1.37% ▲
RUB	36.59	2.01% ▲
KRW	2.24	1.36% ▲
JPY	22.34	-0.22% ▼
CAD	1,922.60	1.83% ▲

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,194.97	-0.16% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	14.09	-0.56% ▼
Эс	USD/lb.	262.40	0.06% ▲
Нүүрс	USD/MT	114.78	1.58% ▲
WTI газрын тос	USD/bbl.	68.95	1.77% ▲
Brent газрын тос	USD/bbl.	78.11	1.67% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.78	0.00%

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VII	7.70%
Бодлогын хүү	2018. VII	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VII	9.80%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VII	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VII	10.70%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 41 компанийн 674.1 сая төгрөгийн 1,605,071 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 14.48%-аар буюу хамгийн ихээр өсч 973.11 төгрөгт хүрч хаагдсан бол “Фронтинер лэнд групп” /MDR/ компанийн хувьцаа 16.00%-аар буурч 210 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 368 ширхэг үнэт цаас 37.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.


9-р сарын 14-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,324.5 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,041.17 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.63%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	711.4
Зах зээлийн үнэлгээ	2,324,456.1

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,041.17	0.63% ▲
MSE I индекс	9,588.93	0.09% ▲
MSE II индекс	9,184.68	0.85% ▲

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	5,750	191,440,100
АПУ	264,700	142,683,107
Монгол базальт	270,385	90,448,053
Эрдэнэ ресурс девелопмент корп.	104,740	67,911,304
ЛэндМН ББСБ	714,311	48,562,171

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	973.11	14.48% ▲
Хай Би Ойл	62.00	12.73% ▲
Айтүүлс	127.90	11.22% ▲
Жуулчин дюти фрий	98,000.00	8.79% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп.	650.00	6.56% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Фронтинер лэнд групп	210.00	-16.00% ▼
Эрэнцэв	5,350.00	-14.67% ▼
Стандарт ноос	350.00	-12.50% ▼
Увс чацаргана	525.00	-12.50% ▼
Улаансан	949.00	-7.86% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Бумбат-Алтай	7,392,413,280
Новел инвестмент	327,715,276
Би Ди Сек	195,631,346
Голомт Капитал	168,133,234
Ти Ди Би Капитал	160,075,812

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	540.24	574,913
Таван толгой	7,900.00	416,055
Говь	32,540.00	253,849
МИК	10,980.00	227,388
Сүү	212.00	72,928

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

### ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

### ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	25	2,500,000	100,000	100,000	104	15.490%
2	ZGEB-BD-06/06/19-A0254-15.49	4	410,640	102,660	102,660	104	15.490%
3	ZGEB-BD-10/10/19-A0336-13.945	59	5,900,000	100,000	100,000	104	13.945%
4	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	280	28,467,600	101,670	101,670	156	15.140%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмэлт хувьцаа гаргалт амжилттай болох боломжтой боллоо

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2-р ангилалд бүртгэлтэй “Хөвсгөл Алтандуулга” ХК нийт 4.4 сая ширхэг буюу нийт хувьцааныхаа 28%-тай тэнцэх хувьцааг нэмж гаргах замаар 3,74 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр олон нийтээс 2018 оны 8-р сарын 16-ны өдрийг хүртэл анхдагч зах зээлийн захиалгыг авсан бөгөөд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг СЗХ-ноос өгсөн чиглэлийн дагуу 2018 оны 9-р сарын 10-ны өдөр хүлээн авч дууслаа.

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн анхдагч зах зээлийн захиалгад нийт 100 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийтдээ 4,405,600 ширхэг үнэт цаасны худалдан авах захиалга өгснөөр нэмэлт үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилттай болох нөхцөл бүрдсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 9-р сарын 12-ны өдрийн 1/3698 тоот албан бичгээр “Хөвсгөл алтандуулга” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Үүний дагуу, тус компанийн үнэт цаасны арилжааг 2018 оны 9-р сарын 14-ний өдрөөс эхлэн нээхээр боллоо.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж



### “Люкс занандуу групп” ХК-ийн хувьцааг худалдан авах тендер санал гаргалаа

“Тозавеллнесс сервисес” ХХК нь “Люкс занандуу групп” ХК-ийн хяналтын багцыг худалдан авсан тул “Компанийн тухай” хуулийн 57.1, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 22 дахь заалт, СЗХ-ны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, худалдан авах үйл ажиллагааны журам”-ын 3.1-д заасан үүргийн дагуу бусад хувьцаа эзэмшигч нарын өмчлөлд байгаа нийт 43,094 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 890 /сүүлийн 6-н сарын жигнэсэн дундаж ханш/ төгрөгөөр худалдан авах тендер санал гаргаж байна.

Санал болгож буй үнэ: 890 төгрөг

Худалдан авах тоо ширхэг: 43,094 ширхэг

Хувьцааг худалдан авах саналын эхлэх хугацаа: 2018.09.10

Хувьцааг худалдан авах саналын дуусах хугацаа: 2018.10.23

Хувьцааны худалдан авах төлбөрийн хугацаа: 2018.10.24

Худалдан авагчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо Үндсэн хуулийн гудамж, Их Үйлсийн эрэлд ХХК-ийн байр 210 тоот

Хувьцаа эзэмшигчдийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж-16, Реженс Резиденс, 3-р давхарт 314 тоот / Монгол шуудан 48-р салбар/

Дэлгэрэнгүй мэдээллийг 99777951 утсаар авна уу.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Ард даатгал” ХК-ийн үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 6 дахь шинэ үнэт цаас, даатгалын салбараас үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж буй анхны компани болох “Ард даатгал” ХК нь нийт хувьцааныхаа 30 хувь буюу 7.5 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 5.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр анхдагч зах зээлийн сурталчилгааг эхлүүлээд байгаа билээ.

Тус компани нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, эрсдэл даах чадварыг сайжруулах, түүнчлэн, СЗХ-ноос батлагдсан “Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага”-ын дагуу зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт захиалгын тоо хэмжээ санал болгож буй хэмжээнээс давсан тохиолдолд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын дагуу хувь тэнцүүлэх зарчмаар нийт хөрөнгө оруулагчдад хуваарилна

Үнэт цаасны худалдан авах захиалгыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан 2018 оны 9-р сарын 17-ны өдрөөс 9-р сарын 26-ны өдрийн 14:00 цаг хүртэл хүлээн авна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Зоос гоёл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Зоос Гоёл” ХК-ийн 2017 оны 4-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэр гаргасныг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон Санхүүгийн зохицуулах хороо “Зоос Гоёл” ХК-ийг үнэт цаасны бүртгэлээс хассан.

Үүнтэй холбогдуулан энэхүү асуудлын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүссэнийг үүгээр мэдэгдэж байна.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрх үүссэн өдөр: 2018.08.29

Хувьцааг эргүүлэн худалдан авах үнэ: 289,440 төгрөг

Жич: СЗХ-ны 2015 оны 366 тоот тогтоолын дагуу нэгтгэгдсэн 1 бүхэл хувьцаа (1 бүхэл = 366 тоот тогтоолоос өмнөх 288 ширхэг хувьцаа)

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авах эцсийн өдөр: 2018.10.15.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### Бүртгэлтэй зарим хувьцаат компаниудын хөрвөх чадварыг сайжруулах талаар СЗХ-нд санал хүргүүлээ

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын чанарыг сайжруулах зорилгоор, хөрвөх чадвар хангалтгүй нэр бүхий 130 компани, үүргийн хэрэгжилт хангалтгүй 95 компани, арилжаа нь зогссон 32 компанид тус тус гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хугацаатай үүрэг даалгавар өгснөөс гадна эдгээр компаниудын зах зээлийн ханш болон дансны үнийн зөрүүг багасгах талаар авах арга хэмжээний саналыг СЗХ-нд хүргүүлээд байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

## ШИНЭ IPO

Үзүүлэлт	“Мандал даатгал” ХК	“Ард даатгал” ХК
<b>Хувьцаа</b>		
Үнэт цаас гаргагч:	“Мандал даатгал” ХК	“Ард даатгал” ХК
Үнэт цаасны символ:	MNDL	AIC
Хувьцааны бүртгэлийн ангилал:	I ангилал	I ангилал
Зарласан хувьцааны тоо:	25,000,000 ширхэг	25,000,000 ширхэг
Эргэлтэд гаргасан хувьцааны тоо:	5,000,000 ширхэг	17,500,000 ширхэг
Халаасалсан хувьцааны тоо:	1,243,016 ширхэг	0 ширхэг
Олон нийтэд санал болгох хувьцааны тоо:	1,560,754 ширхэг	7,500,000 ширхэг
Олон нийтэд санал болгох хувь:	25.00%	30.00%
Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ:	1,000 төгрөг	200 төгрөг
Санал болгож буй хувьцааны нэгж үнэ:	4,800 төгрөг	700 төгрөг
Нэгж хувьцааны дансны үнэ:	1,200 төгрөг	299 төгрөг
Нэгж хувьцааны бизнесийн үнэлгээ:	4,723.83-5,041.72 төгрөг	1,164 төгрөг
Хямдруулсан хувь:	4.8% (5,041.72 төгрөгөөс тооцсон)	39.9%
Нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн үнийн дүн:	7,491,619,200 төгрөг	5,250,000,000 төгрөг
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт:	Хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх	Дүрмийн сан болон өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх
Анхдагч зах зээлийн захиалга авах хугацаа:	2018.09.04 - 2018.09.18	2018.09.17 - 2018.09.26
Анхдагч захиалгын хуваарилалт:	Суурь хуваарилалт хийх мөнгөн дүнг 1 тэрбум төгрөгөөр тооцон нийт захиалга өгсөн хүний тоонд тэнцүү хуваарилна. Үлдэгдэл 6.49 тэрбум төгрөгийг нийт захиалгын мөнгөн дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн хуваарилна.	Хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилна
Ногдол ашгийн бодлого:	Ойрын жилүүдэд ногдол ашиг хуваарилахгүй	Цэвэр ашгийн 30-50%
<b>Компани, 2017 он</b>		
Байгуулагдсан огноо:	2011 он	1994 он
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	1. “Голомт файнэншил групп” ХХК - 51%; 2. “Юу Эм Си капитал” ХХК - 49%	1. “Ард санхүүгийн нэгдэл” ХК - 95.31%; 2. “Энержи интернэйшнл капитал” ХХК - 4.69%
Салбар, нэгжийн тоо:	280 банкны салбар	24 салбар, 238 төлөөлөгч
Даатгуулагчдын тоо:	45,997	26,979
Зах зээлд эзлэх хувь:	16%	11%
Нийт хөрөнгө:	21,472 сая төгрөг	11,727 сая төгрөг
Нийт хураамжийн орлого:	22,533 сая төгрөг	10,355 сая төгрөг
Давхар даатгалд шилжүүлсэн хураамжийн хувь:	50%	32%
Цэвэр хураамжийн орлого:	10,081 сая төгрөг	6,912 сая төгрөг
Цэвэр ашиг:	1,103 сая төгрөг	1,124 сая төгрөг
Цэвэр ашгийн маржин:	4.90%	10.85%
Цаашдын зорилт:	1. Зах зээлд эзлэх байр суурийг өсгөх; 2. Давхар даатгалын хураамжийг бууруулах; 3. Хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх; 4. Жижиг даатгалын компаниудыг нэгтгэх	1. Зах зээлд эзлэх байр суурийг өсгөх; 2. Хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөх; 3. “Монгол шуудан” ХК-ийн салбараар дамжуулан даатгалын үйлчилгээг үзүүлэх

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ҮСХ: Эрдсийн экспорт 21.2%-аар өсөв

Энэ оны эхний 8 сарын байдлаар Монгол улсын гадаад худалдааны нийт эргэлт 8.5 тэрбум ам.долларт хүрчээ. Үүнээс экспорт 4.7 тэрбум доллар, импорт 3.8 тэрбум ам.долларыг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гадаад худалдааны нийт бараа эргэлт 23.7%, экспорт 13.9%, импорт 38.3%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Оны эхний найман сарын байдлаар эрдсийн экспорт мөнгөн дүнгээр 3.98 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 21.2%-аар өссөн дүнтэй гарлаа. Энэ дундаа нүүрсний экспорт орлогын дүнгээр 1.85 орчим тэрбум ам.долларт хүрсэн нь 17.3%-ийн өсөлтийг харуулж байгаа юм. Нүүрсний экспортын биет хэмжээ мөн хугацаанд 23.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.4%-аар өссөн дүнтэй гарлаа. Сарын дүнгээр өнгөрсөн 8-р сард 2.98 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх долдугаар сарынхтай 17%-аар өссөн дүн боллоо.

Мөн гол экспортлогчдоос дурдвал, 9-р сарын байдлаар “Эрдэнэс Тавантолгой” 9.5 сая тонн нүүрс экспортолжээ. Тус компани энэ онд нийт 13 сая тонныг гаргахаар зорьж байгаа аж. Харин Хөшөөтөд олборлолт хийж байгаа “Mongolia Energy Corporation” өнгөрсөн онд бүтэн жилийн хугацаанд 630 мянган тонн баяжуулсан нүүрс экспортолж байжээ. Энэ оны эхний 9 сард энэ үзүүлэлтээсээ хэдийн давсан байна. Оны эцэс гэхэд нэг сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа ажээ. “Энержи Ресурс” компани оны эхний хагас жилд 2.1 сая тонн боловсруулсан нүүрс борлуулаад байна.

Зэсийн баяжмалын экспортын тухайд оны эхний найман сард 959.5 мянган тонныг гадагш нийлүүлж, 1.33 орчим тэрбум ам.долларын орлого олсон байна. Энэ нь зэсийн баяжмалын экспорт биет жингээр 2.1%-аар буурсан бол орлогын түвшин 28.7%-аар дээшиллээ. Харин боловсруулсан цэвэр зэсийн экспортын хувьд мөн хугацаанд жингээр 9085.7 тонн, мөнгөн дүнгээр 59.6 сая ам.долларт хүрсэн нь биет жингийн хувьд 15.6%-аар, орлогын дүн 2.1%-аар тус тус буурсан дүнтэй гарав.

Гол экспортлогчдын нэг “Оюу Толгой” компани II улиралд үйлдвэрлэсэн баяжмал дахь зэсийн хэмжээ 1.5 хувиар нэмэгдэж, алтны үйлдвэрлэл 19 хувиар өссөн талаар “Turquoise Hill Resources” компани санхүүгийн тайландаа дурдсан байна.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны тухайд мөн хугацаанд 3.4 тонныг экспортолж, 144.5 сая ам.долларын орлогын дүнгийн биелэлттэй гарлаа. Энэ нь жин болон орлогын хувьд бараг 60%-аар буурсан үзүүлэлт юм. Гэхдээ Монголбанкны алт худалдан авалтын хэмжээ оны эхний 8 сарын байдлаар 12.2 тоннд хүрч, өмнөх оны мөн үеийнхтэй адил түвшинг харуулсан байна.

Боловсруулаагүй газрын тосны экспортын хувьд 4.4 сая орчим баррелийг экспортолж, 287 орчим сая ам.долларын орлоготой ажилласан дүнтэйгээр оны эхний 8 сарыг үдэж байна. Энэхүү үр дүн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад жингээр 13.3%-аар буурсан боловч орлогын дүн нь 17.3%-аар өссөн гэсэн үг.

Одоогоор “Петрочайна дачин тамсаг” компани газрын тосны XIX, XXI блокоос, “Доншен” компани газрын тосны 97 дүгээр талбайгаас газрын тос олборлон экспортолж байна. Газрын тосны ханшийн өсөлт экспортод эергээр нөлөөлж байна. Нэг баррель брэнт газрын тосны ханш 8-р сарын эцэс гэхэд 78.02 ам.долларт хүрч өсжээ. Энэ нь өмнөх сарынхаас 7 орчим хувиар өссөн байна.

Төмрийн хүдрийн экспортын тухайд оны эхний 8 сард 4.59 сая тоннд хүрч, 210.3 сая ам.долларт хүрсэн нь биет жингээр 20.5%-аар, орлогын дүн нь 2.3%-аар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Цайрын хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 81.2 мянган тонн болж, орлогын дүн нь 138.5 орчим сая долларт хүрчээ. Цайрын экспорт ийнхүү жингээр 0.2%-аар, орлогын дүн нь 16.6%-аар тус тус өсөв.

Жоншны хүдэр, баяжмалын экспортын тухайд оны эхний 8 сарын байдлаар 289 мянган тонныг гадагш нийлүүлж, 97 сая ам.доллар олсон нь биет жингээр 51.4%, орлогын дүнгээр 2 дахин өссөн дүнтэй гарлаа.

Молибдений баяжмалын экспорт эхний 8 сарын байдлаар 3.9 мянган тоннд хүрч, 31.7 сая ам.долларт тэнцсэн нь биет жингээр 6.5%-аар буурсан ч, үнийн дүнгийн хувьд 36.3%-аар нэмэгдсэн дүнг илтгэлээ.

Хар тугалганы худалдааны хувьд 12.4 мянган тоннд хүрч, 31.8 сая ам.долларт тэнцсэн нь жингээр 11.1%-аар, орлогын хувьд 12.8%-аар тус тус нэмэгдсэн дүнтэй гарлаа.

Гянтболдын экспорт оны эхний 8 сард 375.8 тоннд хүрч, 4.27 сая ам.долларын орлого олсон нь өмнөх оны мөн үеийнхээс жингийн хувьд 28.8%-аар буурсан бол орлогын дүн 13.3%-иар дээшилсэн дүн болж байна.

**Эх сурвалж:** MongolianMiningJournal.com

### Барилга Эм Эн: Цементийн хэрэгцээг дотоодын зах зээлээс хангах нөхцөл нэмэгдсэн

“Барилга Эм Эн” компанийн мэдээлснээр дотоодын цементийн борлуулалт 2013 онд нийт борлуулалтын 12 хувийг бүрдүүлж байсан бол 2017 онд энэ тоо 80 хувьд хүрч өссөн байна.

Тухайлбал, 2015 онд жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “Монполимет” компанийн “Монцемент” үйлдвэр, 860 сая тонны хүчин чадалтай “Мөнхийн баян гал” компанийн цементийн үйлдвэр, мөн 2016 онд жилд нэг сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай “МАК” компанийн “Хөх цавын цемент шохойн үйлдвэр” ашиглалтад орсноор цементийн хэрэгцээг дотоодын зах зээлээс хангах нөхцөл нэмэгдсэн байна.

Барилгын үйлдвэрлэлийн хоёрдогч гол түүхий эд болох арматурын дотоодын жилийн хэрэгцээ 212-338 мянган тонн байснаас 19-31 хувийг дотооддоо үйлдвэрлэж, 70-80 хувийг импортоор авч байна. Монгол Улсын хэмжээнд нийт 148 мянга 500 тонн арматур үйлдвэрлэх хүчин чадалтай 14 үйлдвэр ажиллаж байна. Эдгээрээс хамгийн том үйлдвэрлэгчид болох “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “Дөл түшиг” ХХК, “Нийслэл өргөө” ХХК зэрэг зургаан үйлдвэр нийт үйлдвэрлэлийн 97 хувийг бүрдүүлэх хүчин чадалтай гэдгийг “Барилга Эм Эн” компани мэдээлсэн юм. Хэдий тийм боловч эдгээр үйлдвэрүүд хамгийн их нийлүүлэлттэй 2012-2014 онд хүчин чадлынхаа 16-34 хувийг ашиглаж байжээ.

Харин импортоор нийлүүлж буй нийт арматурын 69 хувийг ОХУ-аас, 30 хувийг БНХАУ-аас нийлүүлж байна. Үнийн хувьд БНХАУ-аас импортолдог арматурын үнэ 2017 оны 11-р сараас хойш тогтвортой байгаа бол ОХУ-аас импортолж байгаа үнэ тасралтгүй өсөж байна. Наймдугаар сарын байдлаар нэг тонн арматурын үнэ нэг сая 730 мянгаас нэг сая 793 мянган төгрөг байжээ.

Үүнээс гадна энгийн тоосгоны үнэ оны эхний улиралд өсөх хандлагатай байсан ч эргэн тогтворжсон байна. Мөн хөнгөн блокны үнэ тасралтгүй өсөж, 126 мянга 500 төгрөгөөс 137 мянга 500 төгрөг болгоод байгаа аж.

**Эх сурвалж:** Montsame.mn

## БУСАД МЭДЭЭ

### ҮСХ: Монголын эдийн засгийн 8-р сарын байдал

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 8-р сарын эцэст 17.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 229.1 (1.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.9 (20.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 8-р сарын эцэст 927.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 10.4 (1.1%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 27.9 (3.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 8-р сарын эцэст 15.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 337.6 (2.2%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.7 (20.2%) их наяд төгрөгөөр өсөв.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 8 сарын байдлаар 5.8 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.4 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 8 сард 577.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 8 сард 410.8 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Энэ оны 8 дугаар сард өмнөх сараас улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 158.9 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 149.1 тэрбум төгрөгөөр тус тус буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 9.8 тэрбум төгрөгөөр өслөө.

Татварын нийт орлого 5.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.3 (32.5%) их наяд төгрөгөөр өсөхөд нэмэгдсэн өртгийн албан татвар 352.2 (35.3%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 307.1 (31.1%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 199.4 (67.5%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 179.1 (22.0%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 113.4 (30.7%) төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 98.1 (29.3%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.0 хувийг татварын орлого, 10.4 хувийг татварын бус орлого, 6.9 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.7 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна.

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2018 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 641.0 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 404.6 сая америк доллараар өсжээ.

Монгол Улс 2018 оны эхний 8 сард 147 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 8.5 тэрбум америк доллар, үүнээс экспорт 4.7 тэрбум америк доллар, импорт 3.8 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2018 оны 8-р сард экспорт 554.6 сая америк долларт, импорт 536.3 сая америк долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 27.4 (4.7%) сая америк доллараар буурч, импорт 118.8 (28.5%) сая америк доллараар өссөн байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.6 (23.7%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 568.9(13.9%) сая америк доллараар, импорт 1.1 (38.3%) тэрбум америк доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 8 сард 1.4 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 484.9 (35.8%) сая америк доллараар буурч, 869.2 сая америк долларт хүрчээ. Харин 2018 оны 8-р сард гадаад худалдааны тэнцэл 18.2 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 146.2 (88.9%) сая америк доллараар буурсан байна.

Экспорт 2018 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 568.9 сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 698.0 сая америк доллар, нэхмэл бүтээгдэхүүний экспорт 63.7 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Харин импорт өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 195.6 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 62.3 сая америк доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд анги 229.2 сая америк доллараар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 204.7 сая америк доллараар, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 157.2 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 8 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.8 хувиар буурч, өмнөх оны эцсээс 4.6 хувь, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 8.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 15.8 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Эх сурвалж:** Үндэсний статистикий хороо



### Fitch: Монгол Улсын эдийн засаг 2019 онд 6.3 хувиар өснө

Монгол Улсын эдийн засаг 2018 оны эцэст 5.2 хувь, 2019 онд 6.3 хувиар өснө гэж "Fitch" агентлаг төсөөлж байна. Харин "S&P" агентлагийн тооцоолсноор ирэх гурван жилд эдийн засаг дунджаар 5.5 хувиар өсөх төлөвтэй байна. Уул уурхайн мега төслүүдийн хэрэгжилт хүлээлтээс өндөр байж, эдийн засгийн өсөлт дараагийн нэг жилийн хугацаанд төсөөллөөс давсан тохиолдолд зээлжих зэрэглэлийг сайжруулах боломжтой гэж "S&P" агентлаг мэдэгдсэн юм. Оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын эдийн засаг 6.3 хувиар өссөн нь шинжээчдийн таамгаас даваад байна. Мөн Засгийн газраас ирэх онд "Эрдэнэс Таван Толгой" компанид IPO хийхээ мэдэгдсэн юм. Хэдий тийм боловч "2020 оны сонгууль, түүхий эдийн үнийн уналт Монгол Улсын эдийн засгийн гол эрсдэл" гэж Fitch" агентлагийн Ази, Номхон далайн орнуудын зээлжих зэрэглэл хариуцсан захирал мэдэгдсэн юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.